

ГИБРИД ПОЛИМЕР СУУРЬТАЙ УНИВЕРСАЛЬ ЦАВУУН ЧИГЖЭЭС

АРТИКУЛ: КВР-52Х



Новинка

КВР-522 ХАР, КВР-523.3 СААРАЛ RAL 7016, КВР-523 СААРАЛ, КВР- 524 ЦАГААН

Техник мэдээллийн хуудас. 2023оны
3сар

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Дотор болон гадна ажилд зориулсан. Төрөл бүрийн орчинд ажиллах чадвартай, чичиргээний ачаалалд тэсвэртэй, найдвартай, битүүмжлэх болон холбох завсар үүсгэхэд хэрэглэдэг. Төрөл бүрийн материалаар хийсэн цонхны тавцан, хаалганы босго, гоёл чимэглэлийн хавтан, шат болон бусад барилгын элементүүдийг бетон, тоосго, чулуу, металл, мод

болон бусад гадаргуу дээр битүүмжилж угсрахад хэрэглэдэг. PE PP PTFE-ээс бусад хатуу хуванцар, чулуу, бетон, шил, керамик, хөнгөн цагаан, металл, хайлш, зэвэрдэггүй ган, гипсэн хавтан, PVC, мод гэх мэт ихэнх барилгын материалд маш сайн наалддаг. Тогтмол уян хатан, бат бөх, удаан эдэлгээтэй завсар үүсгэдэг бөгөөд урьдчилж өнгөлөх шаардлагагүй, ашиглалтын өндөр шинж чанартай. Нэг төрөлт, тиксотроп, завсараар тархахгүй, гулсахгүй, ашиглалтын бүх хугацаанд уян хатан чанараа хадгалдаг. Хатсаны дараа усан болон синтетик будгаар будаж болно (уусгагч дээр суурилсан будаг хэрэглэхдээ туршилтын тест хийх хэрэгтэй).

ШИНЖ ЧАНАР

- Агшихгүй, хийн бөмбөлөг үүсэхгүй.
- Хэт ягаан туяа, цэвэрлэгч болон угаагч бодисын нөлөөнд тэсвэртэй.
- Бетон, тоосго, чулуу, шил, металл, гипсэн хавтан, мод, PVC болон ихэнх төрлийн барилгын материалд өнгөлгөө шаардалгүй маш сайн наалддаг.
- Химийн хувьд нейтраль, идэмхий биш.
- Уян хатан чанар өндөр, деформацид тэсвэртэй чанар 20%-иас багагүй.
- Ашиглалтын температурын хүрээ өргөн: -40°C-ээс +110°C хүртэл.

ХЭРЭГЛЭХ ЗААВАР

- +5°C-ээс +35°C хүртэл температурт ажиллахыг зөвлөж байна.
- Цавуун чигжээсийг цэвэр, тослогыг арилгасан гадаргуу дээр хэрэглэнэ. Тослогыг арилгах болон цэвэрлэхэд KUDO <Силикон арилгагч> хэрэглэхийг зөвлөж байна.
- Нарийвчлалтай ажиллахын тулд далдлах лент хэрэглэх ба лентийг цавуун чигжээсийг түрхэсний дараа шууд арилгана.
- Хэрэглэхдээ барилгын тариур (буу) ашиглана.
- Бууны голыг тултал нь гадагш татаж, боолт болон хошууг эргүүлж тайлна, файлуутыг бууны их биед байрлуулж бууг бэлдэнэ. Гадна үлдсэн уутны үзүүрийг болгоомжтой тасалж, хошуу болон боолтыг хэрэгтэй байрлалд бэхлэж, бууг хаана: уутны тайрсан үзүүр хошуунд орсон байх ёстой.
- Тунг тохируулахад шаардлагатай нүх гаргахын тулд үзүүрийг 45° өнцөгөөр таслана.
- Найрлагыг тасалдалгүй, товойлголтгүй, хоосон зай үүсгэлгүй үргэлжлүүлэн тасралтгүй түрхэнэ.
- Бий болсон завсарыг савангын уусмалаар норгосон шпателаар тэгшлэнэ.
- Гадаргуугын хальс үүсэх хугацаа 20минутаас багагүй, цавуун чигжээсний хатуурах хурд хоногт 2-3мм (+23°C температурт, харьцангуй чийгшил 50% байх үед) байна.
- Дөнгөж түрхсэн цавуун чигжээсэнд бохирдсон гадаргууг уусгагчийн (ацетон, цагаан спирт) тусламжтай арилгана. Хатсан цавуун чигжээсийг механик аргаар арилгана.
- Наасан бүтээгдэхүүнийг -40°C-ээс +110°C хүртэл температурт ашиглаж болно.

ХАДГАЛАХ ХУГАЦАА БОЛОН ХАДГАЛАЛТ

Хадгалах горимыг хангасан тохиолдолд 12сар хадгална. +5°C-ээс 25°C хүртэл температуртай хуурай газарт битүүмжилсэн хаалттай оригиналь уутанд хадгална. Тээвэрлэх үед -18°C хүртэл температурт хөлдөөж болно.

НАЙРЛАГА

Гибрид полимер, эрдэст дүүргэгчүүд, функциональ нэмэлтүүд, пигментүүд.

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗААВАР

Хатаагүй цавуунд шууд хүрэх нь нүд болон арьсыг цочроож болно. Харшлын урвал үүсгэж болно. Арьсанд хүрсэн тохиолдолд их хэмжээний усаар угаана. Нүдэнд орсон тохиолдолд муу үр дагавар үзүүлж болно. Нүдэнд орсон тохиолдолд хэдэн минутын турш нүдийг усаар болгоомжтой угаана. Хэрэв контакт линз хэрэглэдэг бөгөөд авахад хялбар байвал авах хэрэгтэй. Нүдээ үргэлжлүүлэн угаана. Шаардлагатай бол эмчид хандах хэрэгтэй. Хүүхэд хүрэхгүй газарт хадгална. Ажиллаж дууссаны дараа гараа сайтар угаана. Бээлий, хамгаалалтын хувцас болон нүд, нүүр хамгаалах хэрэгсэл хэрэглэх хэрэгтэй.

УСТГАХ ЗӨВЛӨГӨӨ

Найрлага болон савалгааг орон нутгийн, бүс нутгийн, үндэсний болон олон улсын зааварчилгааны дагуу устгана. Хүрээлэн буй орчинд хаяж болохгүй.

ҮНДСЭН ШИНЖ ЧАНАР, ТЭМДЭГЛЭГЭЭ БОЛОН СТАНДАРТ

№	Үзүүлэлтүүдийн нэр	Норм	Арга
1	Цэвэр жин, г	930±5	
2	Дүүргэлтийн хэмжээ, мл	600±2	
3	Гадна төрх	Нэг төрлийн зуурмаг	
4	Нягтрал, г/см ³	1,55±0,05	ГОСТ 15139-69
5	Гадаргуугын хальс үүсэх хугацаа (+23°C темп, агаарын чийгшил 50%), минут	20-оос багагүй	
6	Хатуурах хурд (+23°C темп, агаарын чийгшил 50%), мм/24цаг	2,5 – 3,5	
7	Шору А стандартаар хатуулаг	40±5	ГОСТ 263
8	Урсах эсэргүүцэл	Урсахгүй	
9	Агшилт, %	3-аас ихгүй	
10	Хамгийн их суналт, %	300-аас багагүй	ISO 37
11	Хагарлын үе дэх хамгийн их ачаалал, МПа	2,0-оос багагүй	ISO 37
12	Холболтын завсараар хагарлын үеийн хамгийн их ачаалал, МПа	1,3 (AI-AI) багагүй 1,0 (бетон-бетон) багагүй	ISO 8339
13	Хамгийн их суналт, %	200 (AI-AI) багагүй 150 (бетон-бетон) багагүй	ISO 8339
14	Мод-мод дээжний хөдөлгөөн (наасан холбоосын зузаан 1мм), МПа	1,5-аас багагүй	ISO 4587
15	Деформацид тэсвэртэй чанар, %	±20	ISO 9047

САВАЛГАА

600мл файл-уут (хиам шиг), хайрцгандаа 12ширхэг.

ТЭМДЭГЛЭГЭЭ БОЛОН СТАНДАРТ

ТУ 20.30.22-001-01324561-2019

КВР-522 хар

EAN: 4606445044645

ITF: 14606445044642

КВР-523

саарал

EAN: 4606445021950

ITF: 14606445021957

КВР-523.3 саарал RAL 7016

EAN: 4606445048308

КВР-524

цагаан

EAN: 4606445015485

ITF: 14606445048305

ITF: 14606445015482